

Авто зам, гүүрийн зураг төсөл
Зөвлөх үйлчилгээний
“Ар Си Эс Си ХХК



АРХЕОЛОГИЙН ДУРСГАЛ, ТҮҮХ СОЁЛЫН ӨВ

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Бүрэн багийн нутаг Завхан гол дээр барих зам, гүүр барих талбайд археологийн хайгуул судалгааны ажил хийж тус талбайн ойролцоогоос эртний нүүдэлчдийн бүлэг булш бүхифй оршуулгын газрыг илрүүлэв.


Мөн голын урд хөндийд Доной баяны гүүн зэл гэж нэрлэгддэг дурсгал байдаг. Долоон үеэрээ баян явсан долоон мянган адуутай Доной баян нутагладаг байсан. Доной баяны адуун сүргээс шувуун саарал гарсан гэдэг домог яриа байдаг. Зэлний эхнээс нөгөө үзүүр хүртэл 500 гаруй метр. Зэлний эхэнд мөргөсөн хүн баяждаг гэж ярьцгаадаг байна.



“Гүүн зэлний эх” дурсгал

**Завхан гол дээр шинээр баригдах гүүрийн талбайд
археологийн хайгуул судалгаа гүйцэтгэсэн тухай**


“АР СИ ЭС СИ” ХХК-ний гүйцэтгэж буй Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Бүрэн багын нутаг Завхан гол дээр барих зам, гүүрийн зураг төслийн талбайд археологийн хайгуул судалгааны ажил хийж тус талбайн ойролцоогоос эртний нүүдэлчдийн бүлэг булш бүхий оршуулгын газрыг илрүүлэв.



Шинээр баригдах гүүр, замын талбайн ойролцоох дурсгалуудын агаарын зураг

Эдгээр дурсгал нь шинээр барих гүүр, замын талбайгаас урагш 1.2 км зайд, Бүрэн багийн төвийн өмнө орших бөгөөд соёлын өв, археологийн нандин өв мөн юм.

Тухайн дурсгалууд хэдийгээр шинээр баригдах зам гүүрийн талбайгаас зайтай орших боловч туслах зам тавих, гүүрний барилга байгууламжид хэрэглэгдэх түгээмэл тархацтай ашигт малтмал болох чулуун болон шорооны карьер байгуулах, зам гүүрийн трассын чиглэлийг өөрчлөх зэрэг бүтээн байгуулалтын ажилд өртөж устах магадлалтай тул анхаарч ажиллах шаардлагатай. Хэрэв тухайн дурсгалууд буй газарт цаашид ашиглалтын үйл ажиллагаа явуулах, мөн тэдгээр нь гүүрийн бүтээн байгуулалтын явцад өртөгдөж, хөндөгдөх зэрэг нөхцөл байдал бий болох тохиолдолд мэргэжлийн байгууллага, судлаачдад хандаж, дурсгалуудыг авран хамгаалах, хадгалан хамгаалахад анхаарна гэдэгт гүнээ найдаж байна.

Товч тодорхойлолт бичсэн:  ШУА-ийн
хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор Т.Батбаяр

Археологийн